

**МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН
ЭРСДЭЛД СУУРИЛСАН АВЛИГЫН ЭСРЭГ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2025 ОНЫ ТАЙЛАН**

Д/д	Арга хэмжээ	Биелэлт
	1	2
Зорилт 1. Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх		
1.	<u>Арга хэмжээ 1.1.</u> Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контент, зурагт хуудсыг байгууллагын албан ёсны цахим хуудас, сошиал сувгууд, дотоод сүлжээ болон мэдээллийн самбар, бусад хэлбэрээр сурталчилж олон нийтэд хүргэх;	“Мэдүүлэг, мэдэгдэл, тайлбар гаргах тухай”, “Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг” ppt хичээлийг болон Авлигатай тэмцэх газраас бэлтгэн олон нийтэд хүргэсэн авлигын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчил зэрэг видео хичээлийг нийт албан хаагч нарт дотоод сүлжээгээр хүргүүлсэн.
2.	<u>Арга хэмжээ 1.2.</u> Албан хаагчдад авлигын эсрэг хууль тогтоомжийн талаар болон соён гэгээрүүлэх чиглэлээр мэдээлэл өгөх;	ХАСХОМ болон ХАСУМ-ийг хэрхэн мэдүүлэх, анхаарах асуудлын талаар Иргэний хэргийн танхимын болон Захиргааны хэргийн танхимын шүүгч нар, Тамгын газрын албан хаагчид, Шүүхийн академийн албан хаагч нарт сургалт зохион байгуулсан. Тус сургалтыг видео хичээл болгон анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгч нарт хүргэсэн.
3.	<u>Арга хэмжээ 1.3.</u> Шинээр томилогдож ХАСХОМ гаргахаар бүртгэгдсэн албан хаагчдад сургалт зохион байгуулах	Хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах болон албан тушаалын ангилал, зэрэглэл өөрчлөгдөж, томилогдон ХАСХОМ гаргасан 28 албан хаагчид meduuleg.iaac.mn буюу Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн цахим системд мэдүүлэг гаргах албан тушаалтнаар бүртгэгдсэн талаар мэдэгдэж, системд нэвтрэх болон нууц үг сэргээх, хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийн маягт нөхөх зааврыг танилцуулж, хэрхэн гаргах, анхаарах зүйл болон баталгаажуулалт хийх талаар мэдээлэл өгсөн.
4.	<u>Арга хэмжээ 1.4.</u> Хөрөнгө орлогын мэдүүлэг гаргаж буй албан хаагчдад ХАСХОМ-ын системийн талаар мэдээлэл өгөх;	Хөрөнгө орлогын мэдүүлэг гаргасан 66, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг гаргасан 35 албан хаагчид системийн бүтцийн талаар танилцуулга өгч, системд өөрийн мэдээллийг үнэн, зөв бөглөж дууссаны дараа мэдүүлгээ баталгаажуулах талаар болон Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн цахим системд орсон өөрчлөлтийн талаар Тамгын газрын албан хаагчид болон

		Шүүхийн академийн албан хаагч нарт мэдээлэл өгч ажилласан.
5.	<u>Арга хэмжээ 1.5.</u> Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг гаргаж буй албан хаагчдад хэрхэн мэдүүлэх талаар зааварчилгаа өгөх;	Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг гаргасан 35 албан хаагчид хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хэрхэн гаргах, засварлах, мэдүүлгийг хэрхэн баталгаажуулах, томилогдсоноос хойш 30 хоногийн дотор дахин хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах талаар зааварчилгаа өгч ажилласан.
6.	<u>Арга хэмжээ 1.6.</u> Хувийн ашиг сонирхол болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргаж буй албан хаагчдад хэрхэн мэдүүлэх талаар зааварчилгаа өгөх;	Хөрөнгө орлогын мэдүүлэг гаргасан 66, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг гаргасан 35 албан хаагчид системд өөрийн мэдүүлгийг хэрхэн зөв бөглөж, шинэчлэн гаргах, өөрчлөлт оруулах, устгах талаар болон мэдүүлэх гэж буй зүйл нь мэдүүлгийн аль хэсэгт хамаарах, зарим мэдээллийг тайлбар хэсэгт дэлгэрэнгүй бичих, мэдүүлгийг үнэн зөв бөглөж дууссаны дараа хэрхэн баталгаажуулах, баталгааны хуудсыг эрх бүхий албан тушаалтанд хүлээлгэн өгөх, хөрөнгө орлогод их хэмжээний өөрчлөлт орсон тохиолдолд хэрхэн мэдүүлэх талаар зааварчилгаа өгч ажилласан.
Зорилт 2. Ил тод байдлыг сайжруулах, хүнд суртал, чирэгдлийг бууруулах, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх		
7.	<u>Арга хэмжээ 2.1.</u> Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 109 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам"-ыг хэрэгжилтийг ханган ажиллах;	Нийтийн мэдээллийн ол тод байдлын тухай хууль болон Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журамд заасны дагуу байгууллагын цахим хуудаст шилэн дансны цахим хуудсанд хүний нөөцтэй холбоотой мэдээллийн болон Улсын дээд шүүхийн Тамгын газрын бүтцийн нэгжийн чиг үүргүүд болон албан хаагч нарын нэр, албан тушаал, холбоо барих мэдээлэл зэргийг бүрэн байршуулсан.
8.	<u>Арга хэмжээ 2.2.</u> Байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбоотой ирүүлсэн гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлэх;	Ирүүлсэн гомдол, мэдээлэлд жилийн эцсийн байдлаар дүн шинжилгээ хийж, ирэх жилийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхээр бэлдэж байна.